

ОРЧУУЛГЫН БУЛАН



Эдийн засаг, санхүүгийн сэдвээр Дэлхийн хамгийн олон уншигчидтай, нэр нөлөө бүхий “Файнэншиал Таймес” сонины дараах нийтлэл нь бидэнд дохио санамж, гадныханд мэдээлэл өгсөн байх тул орчуулж уншигч танд толилуулж байна. “Файнэншиал Таймес” сонины 2016 оны 9 дгээр сарын 13-ны нийтлэл

ЗЭЭЛЭЭС ЗЭЭЛИЙН ХООРОНД АМЬДРАХ МОНГОЛ УЛС*

Льюси Хорнбай

Таваарын²⁵⁴ бүтээгдэхүүний үнийн өсөлт оргил цэгтээ хүрсэн тэр мөчид Монгол Улс өндөр өсөлттэй шинэ тулгар орны нэг байв. Харин мөчлөг солигдон уруудахын цагт монголын төр засаг, ард иргэд амь амжиргааны бие даасан уламжлалт арга барилаа гээж орхин өрийн дарамтад гүн шигдэв.

“Өртэй хүн өөдлөхгүй, өттэй мал таргалахгүй” гэдэг монгол ардын зүйр үг бий. Улаанбаатарын махны бөөний худалдааны хамгийн том зах дээр лангуу эзэмшигч иргэн Гантүлхүүр Монголд нүүрлээд буй өрийн сүлжээний нэгэн болой. Түүнд өрийн дансны багашаархан дэвтэр бий. Кириллээр нямбайлж жагсаасан нэрсийн цуваа улам бүр тэлсээр буй ажээ. Өөрөөр хэлбэл, мах зээлээр авагсдын нэрсээр түүний данс дүүрч буй хэрэг. Махны жижиглэнгийн наймаачид монголчуудын хүнсний гол хэрэглээ болох хонины махыг бүр жижиглэн хуваах, дотор эрхтэнийг түлхүү борлуулах аргад шилжсэн байна. Учир нь тэдний үйлчлүүлэгчид амь зуулгаа арай ядан залгуулахыг хичээж яваа иргэд. Тэрбээр: “Урьд би бүх махаа өдөрт нь борлуулж амждаг байсан, харин одоо чадахыг больсон. Хүмүүсийн худалдан авах чадвар буурсан” гэв.

Таваарын бүтээгдэхүүний үнэ оргилдоо байх үед Монгол Улс шинэ тулгар орнуудын дотор эрэлт өндөртэй байв. Гадаадын уурхайчид монголын тал хээр, цөл дэх эрдэс түүхий эдийн баялгийг ашиглахаар олноороо ирцгээж, дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2011 онд 17 хувь болтол өсөхөд түлхэц өгчээ. Гэвч үнийн оргил үед олдсон зээлд дулдуйдсан хөөргөн зарлага эрхбиш хумигдахын цагт далайд гарц гэж үгүй мөнөөх Монгол Улс өдгөө сөхөрч сөгдсөн орны нэгэн болжээ.

Монгол Улсын хүндрэлээс гарах оролдлого нь өөрөө баялаг заяасан орнууд “өндийж, урууддаг мөчлөгийн золиос болон баялгаа барах ойлголтыг багтаадаг “баялгийн хараал” ямар аюултай болохыг харуулж байна.

“Туравдагч хөрш”-ийн холбоотон болох Япон, АНУ зэргийг өөртөө татаж, БНХАУ, ОХУ-ын хооронд тэнцвэрийг үргэлжлүүлэн хадгалж чадвал буфер буюу жийргэвч Монгол Улсын хувьд амжилт юм. Энэ нь бүтэлгүйтвэл тэрхүү болгоомжит аядуу тэнцвэр нь хятадын талд ашигтайгаар эргэх боломжтой болж, Монгол Улс Камбож, Лаос эсвэл Төв азийн зарим доройвтор орнуудын замналд татагдан ороход хүрнэ.

* МУИС-ийн ОУХНУС-ийн Ахлах багш Далрайн Даваасамбуу орчуулав

²⁵⁴ Таваарын бүтээгдэхүүнд тариа, будаа, мах зэрэг хүнс, төмөр, нүүрс, зэс, алт, мөнгө зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг нийтэд нь хамруулан ойлгодог. Орчуулагчийн тайлбар

“Монгол Улс шиг тийм их өндөр хүүтэй зээл авдаг өөр улс орон байхгүй. Өөр улс орнууд нэн хүнд эрсдэлтэй тулгардаг байж магадгүй ч хэтэдсэн хүүтэй зах зээлд ордоггүй.” Хэдэн 7 хоногийн өмнөөс Засгийн газраас мөнгөний ханшийн уналтыг зогсоохын тулд төсвийг танаж, бодлогын хүүг 4.5 нэгж хувиар нэмэгдүүлэх нэмэгдүүлэх болсноо зарласан. Монгол Улс дараа жилээс шатлан нэмэгдэх зээлийн төлбөрийн хүндэрлийг даван туулахад дэмжлэг хүсвэл гэдэг утгаар олон улсын санхүүгийн байгууллагууд зээл олгох санал бэлтгэж байна. Үүнтэй зэрэгцэн хятадын зээлдэгчид өрнөдийн хөрөнгө оруулагчдыг гомдоллож байх завсар хооронд хөрөнгө оруулалтын ихээхэн хөнгөлөлттэй нөхцөл бий болгож байна. Эцсийн дүнд сангийн хямралыг зохицуулж чаддаг юм гэсэн ч хувь хүн, бизнес эрхлэгчид албадан тулгасан өндөр хүүтэй өрийн асуудалтай тулгарсаар байх юм. Нүүдлийн амьдралтай хэмээн нэгэнтээ ойлгогддог байсан монголчуудын дийлэнх нь өдгөө хотын иргэд болж, амь амжиргааны бие даасан уламжлалт арга барилаа гэж орхин түүнийгээ бараг хүн бүр зээлтэй байдаг нэгэн орчноор сольж байна.

Дэлхийн банкны судалгаагаар уул уурхайн орлого нь ажлын байр бий болгож, нийгмийн халамжийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг болж, үр дүнд нь 2014 онд 4 жилийн өмнөх 39 хувьтай байсан ядуурлын түвшин буурч, 22 хувь болжээ. Гэвч хотод амьдарснаар хүнс, хувцас хунараас эхлээд хүүхэд асрах хүртэл бүхий л зүйлд мөнгө зарцуулах болдог. Гэтэл нөгөө талд ажлын байр, мөнгөний боломж хомсдож байна.

Шинэчлэх боломж

Гантүлхүүр “мөнгөө төлж чадахгүй зээл авах явдал өнгөрсөн намраас нэмэгдэж, амьдрал нэг л төвөгтэй болсон гэсэнээ үгээ тасалж “Энэ бүгдийг танд яривал зүгээр үү?, Улсынхаа талаар бараан зүйл ярьсандаа санаа зовчлоо” гэв. Өнгөрсөн сард Монголын төр, засаг төсвүүдийг нэгтгэн үзэж, зардлаа хассан ч алдагдал нь ДНБ-ий 18 хувьд хүрч, хуулиар тогтоосон 4 хувийн босгоос хавьгүй хэтэрсэн, засгийн газарт хамаарах гадаад зээлийн өрийн үлдэгдэл байвал зохих 55 хувиас давж, 78 хувь болсон талаар мэдээлэл хийн, олон нийтэд дохио санамж өглөө. Тус мэдэгдлийн дараагаар ам.доллар худалдаж авах нь өсч, төгрөгийн ханш унан, 8 дугаар сард дэлхийн хамгийн их ханшаа алдсан мөнгөн тэмдэгт болсон. Долларын ханш 15 хувиар өсөж, нэг өдөр гаргах валютын хэмжээнд хязгаарлалт тогтооход хүргэж байжээ.

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 23.5 тэрбум ам.долларт хүрч, 12 тэрбум ам.долларын эдийн засгийн хэмжээнээс нь 2 дахин их болжээ. Түүнээс 8.4 тэрбум орчим ам.доллар нь Засгийн газрын өр байна. Монгол Улсын Их Хурлын гишүүн, эрх баригч Монгол Ардын Намын засаглалын үед санхүүгийн салбарт алба хашиж байсан Гомбожавын Занданшатар хэлэхдээ, “өнгөрсөн жилүүдэд нөхцөл байдал ихээхэн муу болсон ч энэ нь бидэнд эдийн засагт шинэчлэл хийх боломж ” хэмээжээ.

Шинэчлэлийн бодлого бүсээ чангалах, таваарын бүтээгдэхүүний ээлжит мөчлөг удахгүй сэргэнэ гэсэн найдвар тавьж, уул уурхайн томоохон төслүүдээ эргэлтэд оруулах ажлын хослолоос бүрдэх ажээ. Томоохон гадаад төлбөрүүдийн ээлж ирэх 3 дугаар сард төлөгдөх Хөгжлийн банкны 580 сая ам долларын бондын эргэн төлөлтөөр эхэлнэ.

Хятадын Төв банкттай хийсэн валют солилцооны свопын төлбөрийг оруулаад Монгол Улс ирэх 2 жилд 1.7-1.8 тэрбум ам.долларын гадаад төлбөр хийхээр байна. Монгол Улс Олон улсын валютын сангаас албан ёсоор дэмжлэг хүсээгүй ч энэ намраас ийм хүсэлт гарна гэсэн хүлээлт байна. Хэрвээ хүсэлт гаргавал Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Монголын хамгийн том хөгжлийн тусламж олгогч Япон өмнөх үеийн зээлээс нэлээдгүй хямдхан, 1 орчим хувийн хүү бүхий зээл олгож, хувь нэмрээ оруулж болох юм гэж харж байна. Мөн БНХАУ-ын Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк шинэ төслүүдэд зориулж 2.5 хувь хүртэл хүүтэй зээл олгож магадгүй аж.

Монгол Улс 2009 онд ОУВС-тай хамтран ажилласан бөгөөд түүнээс авсан 232,0 сая ам.долларын зээлийг монголын экспортын гол нэр төрөл болох нүүрс, зэсийн үнэ өндөр байхад амжин төлжээ.

Мөн өнөө цаг үед ч гэсэн тус улсын санхүүгийн байдал таваарын бүтээгдэхүүний үнийн сэргэлтээс дахин хамаарахаар байна. Зэс, алтны Оюутолгой уурхайн 5.3 тэрбум ам.долларын өргөтгөл нь 2021 оны орчмоос эхлэн олборлолтын хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох хүлээлт байна. Гэхдээ Рио Тинтоогоос “либор²⁵⁵.дээр нэмэх 6.5 хувь” гэсэн аргачлал бүхий хүүтэй зээлээр санхүүжиж буй Монголын талын гуравны нэгийн хувьцааны ногдол ашгийн барааг 15 жилээс нааш үзэхгүй юм.

Зээлэх соёл

Сүүлийн 10 гаруй жил улстөрчид сонгууль бүрийн өмнө уул уурхайн ашиг огцом нэмэгдэх мөрөөдөл ярьж, нийгмийн зардлыг өсгөх амлалт өгсөөр байгаад бүр сүүлдээ түүнээсээ Монгол Ардын нам, өнгөрсөн 7 дугаар сард томоохон ялагдал хүлээсэн Ардчилсан нам ч буцаж чадахаа байжээ. Төсвийн алдагдлыг 4 хувийн хязгаараас хэтрэхээс зайлсхийхийн тулд олон төрлийн ажлыг төсвийн тооцоонд оруулахгүйгээр хэрэгжүүлж байжээ.

Мөн захиргааны албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, алдарт популист амлалтын нэг болох “хүүхдийн мөнгө” буюу эсвэл оюутны тэтгэлэг зэрэг хөтөлбөрүүд багтдаг байна. Найдлага хүслэн болсон уул уурхайн томоохон төслүүдэд зарим төрлийн зээл авсан ч хугацаандаа хэрэгжиж чадахгүй, төлбөрийн хүндрэл учруулж, хойшлуулахад хүргэж байна. Үүнээс цаашлаад олон улсын зах зээлд гаргаж худалдсан бондын асуудал бий. Хамгийн сүүлд 10.5 хувийн хүүтэй бонд гаргажээ. Гадаадын нэгэн банкир “Монгол Улс шиг ийм өндөр хүүтэй зээл

²⁵⁵ Либор нь London interbank offered rate буюу Лондонгийн банк хооронд санал болгодог хүү. Оюутолгойн хэлэлцээр байгуулагдаж байсан 2009 оны 3 дугаар сард 2,1 хувь, 2016 оны 9 дүгээр сард 1.56 хувийн хүүтэй байна.

авдаг улс орон байдаггүй. Зарим улс орон илүү эрсдэлтэй тулгардаг байж магадгүй ч ийм зах зээлд орж ирдэггүй” гэсэн.

“Хятадын бизнес эрхлэгчид) Монголыг залгина. Хэдхэн арван жилийн дараа бид Ар Монголын өөртөө засах орон болно.” Зээллэг нь Монголын амьдралыг өөрчилсөн. Улсын татаас бүхий ипотекийн зээлжилт нь дунд давхаргын залуу хосуудад орон сууцтай болох боломж олгосны зэрэгцээ уул уурхайн оргил хөгжил дээр суурилан гарч ирсэн үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөрөгдөл бий болгоход нөлөөлсөн. Аймаг бүрийг авто замаар холбох төсөл хэрэгжиж, дотоод, гадаадын жуулчдад газар нутгаа нээх боломж гарч байна. Алс холын үзэсгэлэнтэй байгальдаа өөрийн машинаар хоногтоо хүрэх боломжтой болсон. Жип, Ланд ровер машинаар үйлчлэх англи хэлтэй монголчуудын эрхэлдэг аялал жуулчлалын жижиг компаниуд олширчээ.

Өр үүсгэн босгосон зам болон дэд бүтцийн зээлийн эргэн төлөлт нь энэ оны төсвийн алдагдлын томоохон бүрдэл хэсэг болж, улмаар ирэх жилд ДНБ-ий 12 хувийг эзлэх төсвийн алдагдал харьцангуй бодитой болох юм. Гэвч уналтад орсон уурхайчдын авсан зээл, замын тендерт шалгарагсад нь сэтгэл зовоож байна. Барилгын бизнес эрхлэгчид Монголын өндөр хүүтэй зээлээс бага хүүтэй Хятадын зээлийг авахыг хичээдэг гэсэн таамаг байна. Гэвч төгрөгийн ам доллар, юаньтай харьцах ханшийн уналт зээлийг эргүүлэн төлөхөд илүүтэй хүндрэл учруулна.

Энэ бүхэн нь нийт монголчуудын айдас юм. Энэ нь Монгол Улсын хувьд тулгараад буй бодит айдас юм. Найман зууны тэртээ Евразийн ихэнх нутгийг эзэгнэж байсан Монголын газар нутаг яван явсаар XX зууны эхээр Хятад, Оросын дунд хувааж үлдээсэн өнөөгийн хэмжээнд хүртэл багасчээ. Өдгөө Монгол Улсын нутаг нь уул, тал хээр, говийн бүсээс бүрддэг бөгөөд хэмжээгээрээ Францхтай ойролцоо юм. Хэдэн арван жилийн турш Зөвлөлтийн дагуул байсан Монгол Улс 1990 оноос хойш ардчилсан засаглалтай болжээ. Монголын 3 сая иргэн говь цөлийн тэртээх 1.3 тэрбум хятад иргэдтэй өрсөлдөж чадахгүй гэдгийг хүн амын ихэнх нь ухаардаг.

Корпорациуд эсвэл тэднийг хянадаг УИХ-ийн гишүүн бизнесменүүд ямар нэгэн хэмжээгээр хятадад өртэй болохыг хүн бүр гадарладаг. Хятадын ардын банктай байгуулсан жилийн 6,5 хувийн хүүтэй 15 тэрбум юань солилцооны гэрээний хүрээнд 11 тэрбум юань (1.6 тэрбум ам.доллар)-ийг төгрөгийн ханшийг хамгаалах зорилгоор авч ашиглаад байна. Монголын улстөрчид 2017 онд дуусгавар болох энэхүү валют солилцооны хэлэлцээрийг сунгана гэсэн төсөөлөлтэй байна.

Уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагааны төслүүдийг хойшлуулсан, гэрээг нь өөрчлөөд байгаад хятадууд тэвчээр алдаж байна.

Монголд байгаа 7000 орчим хятадын жижиг аж ахуй эрхлэгчдэд илэрхий үйлчлэх Хятадын банкны салбарыг Улаанбаатарт нээхийг эсэргүүцсэн лоббийг монголын банкууд идэвхтэй явуулж байна. Монголын банкуудын зээлийн хүү 22-28 хувь, хувиараа зээлдүүлэгчдийнх 36 хувь байдаг байна. Хятадын банкуудын

компанийн зээлийн хүү энэ оны 6 дугаар сарын байдлаар 5,6 хувь, харин банкны албан бус салбарынх голчлон 10-20 хувийн хүүтэй.

Түрэмгийллийн айдас

Монголын зээлдэгчид зээлийнхээ өрийг Хятадын банкны бага хүүтэй зээлийг ашиглан төлснөөр хятадын бизнест давуу байдал үүснэ гэж Монголын банкирууд эмээж байна. Энэ нь дотоодын банкуудыг зах зээлээс шахаж, Монголын эдийн засаг Хятадаас улам хараат болно. “Тэд Монголыг залгина, Хэдхэн арваар яригдах жилийн дараа бид Ар Монгол хэмээх автономит улс болох вий” гэж нэгэн бизнесмен бухимдан ярьсан. Монголын хувиараа зээлдүүлэгчид төгрөгийн ханшийн уналтаас аль хэдийн “шатаад” эхэлжээ. Олон хүн гадаадаас хямд зээл олж, машин худалдан авагчид, жижиг бизнес эрхлэгчид, аргагүйдсэн хүмүүст зээл олгож байна. Ийм төрлийн зээллэгээр Улаанбаатарт хааяагүй байдаг ломбардуудыг санхүүжүүлж байна. Эдгээр ломбардуудын зарыг багтаах шар туузанд телевизор, гар утас, нөтбүүк барьцаалан зээл аваарай гэсэн сурталчилгаанууд бий. Зарим ломбардын хаалган дээр 14 хоногийн 9 хувийн хүүтэй зээл олгоно гэсэн зар байдаг. Арай бага буюу 30 гаруй хоногт 8 хувийн хүүтэй зээл олгодог дэлгүүрийн ажилтан эмэгтэй, манайхаар үйлчлүүлэгчдийн хөл их байгаа. Харин барьцааны хөрөнгийн үнэлгээ сүүлийн жилд буурч байна гэсэн юм.

УИХ-ын гишүүн Г.Занданшатарын ярьснаар бүр 2018 оны тэтгэвэр, цалингаа барьцаалсан зээлтэй хүн олон байдаг ажээ. Энэ нь мөнгөний гачигдалд орж буйн илрэл юм. Банкууд тэтгэвэр, цалингийн зээлд 18 хувийн хүү төлүүлж байгаа нь шийтгэл мэт тусаж, ядуусын нийт өрийн дарамтыг улам нэмэгдүүлж байна. Ийм хүндрэлтэй асуудал гэр хороололд илүү хурц агаад хөдөөнөөс шилжин суурьшилт хурдтай явагдаж, хүн амынх нь тэн хагас Улаанбаатарт төвлөрөөд байна.

Өргөжин тэлж, хөглөрсөн гэр хорооллыг цахилгаан усаар арай ядан хангаж байна. 9 ам.доллартой дүйцэх хүүхдийн 20 мянган төгрөг зэрэг нийгмийн халамжийн хөтөлбөрүүд олон өрхийн амьжиргааны гол эх сурвалж болж байна. Ханын цаас нь ногоон судалтай, харанхуйлж хаасан цонхны хөшигтэй, нам гүмхэн зоогийн газарт хүмүүс тухлан сууж, улс, орны болон амин хувийн амьжиргааны талаар хөөрөлдөнө. Тэдний олонхид төр улс, хувь иргэний төсөв санхүү амин холбоотой нь ойлгомжтой бөгөөд Хятадаас улам хамааралтай болж байгаад санаа зовнино. Зоогийн газрын эзэн Эрдэнэбаяр хэлэхдээ: Бид “өрөөс өрийн хооронд амьдарч байна”, бодлогогүй хийх бизнес нь таваарын бүтээгдэхүүний болзошгүй үнийн савалгаатай агаар нэг буюу адилхан эрсдэл дагуулна.

“Монголчууд бүгд хөдөлмөрлөж байгаа хэдий агаар ч өртэй. Бид бусад улсад өртэй. Монгол хүний хувьд санааг минь зовоодог” гэж тэрээр мөн хэлэв. Нүүдлийн малчид нэн орчин цагийн амьдралын хэв маягтай тулгарч байна. Монголын тэдгээр нүүдэлчин ард ч өрийн зангуунд орж гүйцжээ. Монголын хээр талд ч өр зээлийн мөнөөх сүлжээ жилээс жилд амьдралын нь хэвшил болж буй гэлтэй. Хээр талын малчин ард ноолуурын орлогоос ашиг олдог ба тэр орлого нь буурах мөчлөг

бүрийд цаг үеийн золиос болж хоцордог. Дээр нь бэлчээр нутаг нь доройтох болжээ. Малчид хаварт ноолуураа, намарт махаа борлуулж амьдарна. Олсон орлого нь нөгөө л өмнөх зээлийн өрөнд явж дахиад шинээр зээл авна. Түүний хүү жилийн 20%-иас давна.

Олон малтай бол зээл олдох нь хялбар ч тэдгээр мал нь бэлчээрийг сэргэхийн завдалгүй дордуулж орхино. Ноолуурыг бий болгодог ямаан сүрэг бэлчээрийг илүү ихээр талхална. Ноолуур бол цэвэр ургац л гэсэн үг. Ихэвчлэн экспортод гарна, нэгэн аялагчийн вэб хуудаснаа бичсэнээр, нүүдэлчдийн АТМ (мөнгөний машин) хэмээжээ. Гэвч ямаа нь тэмээ, адуу, үхрээс илүүтэй бэлчээр сүйтгэдэг. Өвсний чанар доройтож нэр төрөл нь цөөрсөн ч олон малтай мөнөөх малчид нөгөө л өөрт ногдсон хуваарьт газар дээр амь зуулгаа залгуулна.

Засгийн газар тооноос чанарт шилжих бодлогыг хөхиүлэн урамшуулах оролдлого хийж байна хэмээн мэдэгдэж байна. Гэвч малчин бүр бэлчээрийг хамгаалан сэргээх зорилгоор малаа заазлаад эхлэх бол махны үнийн уналт бий болж зээлээ төлж дийлэхгүйд хүрнэ. Малчин бүрт бэлчээр нутгаа сэргээх хүсэл байвч махнаас олсон хэдэн төгрөг нь банкны зээлийн төлбөрт яваад зүйл дуусна. Малчид толгой дараалан өртэй. Олон малтай бол та их өртэй хэмээн мотоцикл хөлөглөсөн 20 эргэм насны нэгэн залуу малйитал инээн өгүүлнэ. Тэрээр бас л 2 сая (900 USD) төгрөгийн өртэй бөгөөд тэр нь Улаанбаатарт оршин суугч иргэний 3 сарын цалинтай тэнцэнэ. Батзориг, түүний дүү хоёр малынхаа нэг хэсгийг эргэлтэд оруулж, ачааллыг багасгаж өгсөн ээждээ талархаж байгаа. Тэр эмэгтэй хэдэн жилийн өмнө өрхийн малаа 600-аас 400 толгой болгон цөөлж, хүүдээ хотод байр авч өгчээ.